

Төрийн нарийн бичгийн даргын
2022 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн
67 дүгээр тушаалын 13 дугаар хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Засгийн газрын 2021 оны 265 дугаар тогтоол, 2022 оны 23 дугаар тогтоол

Дагаж мөрдөх огноо:

2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Боловсрол, шинжлэх ухааны яам

Нэгжийн нэр:

Ерөнхий боловсролын бодлогын удирдлага зохицуулалтын газрын Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс

Албан тушаалын нэр:

Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бодлогын, удирдлага, зохицуулалт, тайлагналт, шим тэжээлийн асуудал хариуцсан шинжээч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ахлах түшмэл, Т3-9

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44, Засгийн газрын III байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Суралцагчийн хоол, хүнсний хангамж, үйлдвэрлэл, үйлчилгээ, хоол шим тэжээлийн боловсрол олгох чиглэлд эрхзүйн орчныг боловсронгуй болгох, үр дүнтэй хэрэгжүүлэх төлөвлөлтийг хийх, удирдлага зохион байгуулалтаар хангаж гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Засгийн газрын 2021 оны 265 дугаар тогтоол, 2022 оны 23 дугаар тогтоол

Дагаж мөрдөх огноо:

2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Боловсрол, шинжлэх ухааны яам

Нэгжийн нэр:

Ерөнхий боловсролын бодлогын удирдлага зохицуулалтын газрын Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс

Албан тушаалын нэр:

Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бодлогын, удирдлага, зохицуулалт, тайлагналт, шим тэжээлийн асуудал хариуцсан шинжээч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ахлах түшмэл, ТЗ-9

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44, Засгийн газрын III байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Суралцагчийн хоол, хүнсний хангамж, үйлдвэрлэл, үйлчилгээ, хоол шим тэжээлийн боловсрол олгох чиглэлд эрхзүйн орчныг боловсронгуй болгох, үр дүнтэй хэрэгжүүлэх төлөвлөлтийг хийх, удирдлага зохион байгуулалтаар хангаж гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Суралцагчийн хоол хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний хүнсний хангамж, хүртээмж, чанар, аюулгүй байдалтай холбоотой эрхзүйн баримт бичгүүдийг боловсруулж батлуулах, төрийн захиргааны байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;
- 2.Суралцагчийн хоол хүнсний хангамж, хүртээмж, чанар аюулгүй байдлыг хангуулахад чиглэсэн төлөвлөлт, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- 3.Суралцагчдад хоол шим тэжээлийн боловсрол олгох, хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах
- 4.Суралцагчийн хоолны норматив зардал болон тухайн жилд тухайн жилд шаардагдах зардлыг төсвийн төсөлд тусгах, хэрэгжүүлэх бодлого төлөвлөлтийн арга хэмжээ авч хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах;
- 5.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд:	1.Боловсролын тухай хууль болон суралцагчийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбогдон гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг удирдлагаар хангах, хяналт тавих;	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсанаар хоол үйлдвэрлэл, үйлчилгээний аюулгүй орчин бүрдэнэ.	Г
	2.Холбогдох хууль, тогтоомж, эрхзүйн бичиг баримт бичиг, нормативт нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх, төсөл боловсруулах;	Судалгаа, тооцоололд үндэслэгдсэн, хуульд заасан бүтэц, хэлбэр, эх бичвэрт тавигдах шаардлага хангасан байна.	Г
	3.Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хууль, тогтоомж, бодлогын баримт бичигт заасан зорилтыг хэрэгжүүлэх дунд болон богино хугацааны төлөвлөлт хийх, хэрэгжилтийг арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангах;	Судалгаанд үндэслэсэн, олон улсын чиг хандлагатай байна.	Г
	4.Суралцагчийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний бодлого, төлөвлөлтийг хангах чиглэлээр Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх асуудлын төсөл боловсруулах;	Судалгаанд үндэслэсэн, олон улсын чиг хандлагатай уялдсан байна.	Г
	5. Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны	Хууль тогтоомжийн хүрээнд удирдлага, арга зүйгээр хангагдсан байна.	Г



	байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;		
	6.Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллах төсөл боловсруулах.	Тулгамдсан асуудлыг тодорхой тусгасан, олон улсын чиг хандлагатай уялдсан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд:	1.Суралцагчийн хоол хүнсний хангамж, худалдан авалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх шийдвэрийн төсөл боловсруулах;	Холбогдох төрийн байгууллагуудтай хамтран шийдэл гаргасан байна.	Г
	2.Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хангамж, хүртээмж, аюулгүй байдал, шим тэжээлийг хангуулах;	Холбогдох эрхзүйн орчныг бүрдүүлж, эрсдэлээс урьдчилан сэргийлсэн байна.	Г
	3.Сургуулийн хоол үйлдвэрлэлийн орчин, хоолны шим тэжээлийн чанар, орчинд хяналт, шинжилгээ хийх удирдамж, шалгуур үзүүлэлтийг боловсруулж хэрэгжилтийг удирдлагаар хангах;	Шалгуур үзүүлэлт батлагдсан байна.	Г
	4.Суралцагчдыг ундны цэвэр усаар хангах бодлого төлөвлөлтийг хийх, хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангах;	Суралцагчид ундны цэвэр усаар хангагдах нөхцөл бүрдсэн байна.	Г
	5.Хоол хүнсний хангамжид орон нутгийн хүнс, үйлдвэрлэлийг дэмжсэн, тохирлын баталгаанд хамруулсан хүнсний түүхийг эд бүтээгдэхүүнийг нийлүүлэх, сургалтын байгууллагын дэргэдэх туслах аж ахуйг хөгжүүлэх шийдлийг боловсруулах.	Орон нутгийн онцлогт тохирсон хүнсний хангамжийн тогтолцоо бүрдсэн байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Хоол шим тэжээлийн боловсрол олгох ажлын төлөвлөлтийг хийх, хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангах	Суралцагч болон оролцогч талуудын хоол шим тэжээлийн мэдлэг дээшилсэн байна.	Г
	2.Эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрийн агуулгыг сайжруулах, төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах	Эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрийг үнэлэн сайжруулсан байна.	Г



	3.Хоол шим тэжээлийн боловсрол олгох хүний нөөцийн бодлогыг тодорхойлох	Суралцагчдад хоол шим тэжээлийн боловсрол хүрэх түвшинд хангагдсан байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Суралцагчийн хоолны норматив зардлыг инфляцын түвшин болон суралцагчийн шим тэжээлийн хэрэгцээг харгалзан шинэчлэн тогтоох, хэрэгжүүлэх төлөвлөлтийг хийх;	Батлагдсан нормативыг хангах түвшинд, хууль тогтоомжид нийцсэн шийдлийн хувилбартай боловсруулагдсан байна.	Г
	2. Тухайн жилд шаардагдах нийт зардлыг нэгтгэн тооцож, төсвийн төсөлд тусгах, үе шаттай хэрэгжүүлэх төлөвлөлтийг хийх;	Тооцоо судалгаанд үндэслэн жил бүр батлагдсан байна.	Г
	3.Суралцагчийн хоолны хүнсний аюулгүй байдал, шим тэжээлийн байдалд цахим хяналтыг нэвтрүүлэх;	Хоол хүнсний чанар аюулгүй байдал хангагдсан байна.	Г
	4.Боловсролын салбарын статистикийн маягтад хоол үйлдвэрлэлийн орчин, хүүхдийн өсөлт хөгжлийн үзүүлэлтийг нэмж тусгаж, үнэлэлт дүгнэлт өгөх.	Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, батлуулна	Г
5 дугаар зорилтын хүрээнд	1.Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, дүгнүүлэх ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх;	Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна.	Х, Г
	2.Яамны удирдлага, бусад нэгжээс шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл судалгааг шуурхай, чанартай, гаргаж өгөх;	Мэдээ, мэдээллийг бодит, үнэн зөв гаргасан байна.	Г
	3.Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлж, эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг “Яамны хөтлөх хэргийн жагсаалт”-ын дагуу архивын нэгж болгон хадгалуулах;	Архив албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцсэн байна.	Г
	4.Төрийн бус байгууллага иргэдтэй эрхэлсэн ажлын чиглэлээр хамтран ажиллах, зөвлөгөө, мэдээлэл өгөх;	Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна.	Т, Г, Х
	5.Хэлтсийн төлөвлөгөө, тайланг боловсруулах, тайлагнах;	Хууль тогтоомжийн хүрээнд цаг хугацаанд гаргасан байна.	Г



	6.Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, чиглэлийг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэх.	Хууль тогтоомжийн хүрээнд биелэлтийг хангуулсан байна.	Х, Г
--	---	--	------

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	- Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх	
Мэргэжил	- Хүнс үйлдвэрлэлт /0721/, хоол зүй, тэжээхүй ухаан /541700/, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи /541600/.	
Мэргэшил	- Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх	
Туршлага	- Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - суралцагчийн хоол, үйлдвэрлэл үйлчилгээний бодлого, стандарт аливаа асуудлыг оношлох, шалтгааныг тодорхойлох, задлан шинжлэх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг оновчтой тайлагнах; - судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх; - мэдээлэл цуглуулах, нэгтгэн боловсруулах; - бодлогын үндэслэлтэй зөвлөмж боловсруулах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх; - эрхлэх асуудалд хамаарах ажил үүргийг хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн чанартай гүйцэтгэх; - бодит баримт нотолгоонд тулгуурлан асуудлын шийдлийн хувилбарыг боловсруулж түүний шалтгаан, үр дагаврыг тодорхойлон нэгжийн удирдлагад танилцуулах; - салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлаар хууль тогтоомж болон нийтийн эрх ашигт нийцсэн, оновчтой, үр дүнтэй санал боловсруулах; - эрхлэх асуудлын хүрээнд аливаа асуудлыг хууль болон төрийн албаны зарчимд нийцүүлэн ашиг сонирхлыг зөрчлөөс ангид шийдвэрлэх; - шийдлийн хувилбар, санал, мэргэшлийн зөвлөмж, зөвлөгөөний үнэн зөв байдал, үр дагаврыг хариуцах; - бусад.
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа эерэг мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч нээлттэй харилцааг бий болгох; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгох хүрээлэлд дасан зохицох, үр бүтээмжтэй ажиллах; мэдлэг туршлага ур чадвараа бусадтай хуваалцах; - хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг дэмждэг байх; - бусад.



	Бусад	<ul style="list-style-type: none"> - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажлын цагийг баримтлан ажиллах; - харилцааны соёлыг эрхэмлэн, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; - жөндөрийн эрх тэгш байдлын зарчмыг баримтлах; - албан ажлын чиг үүргийн дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр ханган ажиллах чадвартай байх; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - төрийн албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, найруулгын чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - бие даан хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, шуурхай засах, дүгнэлт хийх чадвартай байх; - албан ажлын хүрээнд олж авсан мэдээллийг нууцлах; - харилцааны оновчтой арга хэлбэрийг ашиглаж, асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг шуурхай хүргэх; - төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах.
--	-------	--

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
 Ерөнхий боловсролын бодлогын удирдлага зохицуулалтын газрын дарга
 Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

-байхгүй

Бусад харилцах субъект

- Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хэлтэс;
- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн ажилтан;
- Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаал:

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ

.....
 (Гарын үсэг)

/Б.ГАНТУЛГА/

2022 оны ... дүгээр сарын ...-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 22 03 30

Дугаар: 167

Албан тушаалын тодорхойлолт баталсан:



Байгууллагын нэр:

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

Шийдвэрийн огноо: ... 2024.04.04 ...

Дугаар: ... 8/24 ...

(тамга/ тэмдэг)

ТӨРИЙН НАРИЙН БИЙГИЙН ДАРГА

.....
[Signature]

(Гарын үсэг)

/Л.ЦЭДЭВСҮРЭН/

(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

